



## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙГ ТОДОРХОЙЛОХ ОНОЛ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

### THEORETICAL AND METHODOLOGICAL ASPECTS OF DEFINING THE ETHICS OF PUBLIC OFFICIALS

Алтангэрэлийн Алтанзул<sup>1</sup>

National Academy of Governance, E-mail: [altanzul@naog.gov.mn](mailto:altanzul@naog.gov.mn),

#### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

##### Түлхүүр үгс:

ёс суртахуун, ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, нийтлэг шаардлага, үүрэг, хориглох зүйл, ёс зүйн зөрчил, эрх зүйн зөрчил, ёс зүйн хариуцлага, хууль зүйн хариуцлага

##### Keywords:

Ethics and morality in the civil service encompass general requirements, duties, and prohibitions established by ethical standards. Ethical and legal violations entail corresponding ethical and legal responsibilities

##### Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 10 сар  
Шинэчилсэн: 2025, 10 сар  
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

##### Article history:

Received Oct, 2025  
Revised Oct, 2025  
Accepted Oct, 2025

#### ХУРААНГУЙ

Төрийн албан хаагчийн ёс суртахуун, төрийн албан хаагчийн ёс зүй гэх ухагдахууныг тайлбарлах замаар төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ангилалт, төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн шаардлага болох үүрэг, хориглох зүйлийг зөрчсөн үйлдлийг ёс зүйн зөрчил гэж нэрлэх тухай, хууль зүйн хариуцлагын нэг төрөлд ёс зүйн хариуцлагыг багтаах талаар саналаа дэвшүүлнэ.

##### Abstract

The study seeks to clarify the notions of civil servants' morality and civil service ethics in order to define the general ethical norms, categories, and requirements applicable to civil servants. Furthermore, it argues that breaches of duties and prohibitions prescribed by these ethical norms constitute ethical violations, and proposes including ethical responsibility as a type of legal liability.

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



<sup>1</sup>Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, доктор (PhD), дэд профессор

## 1. Танилцуулга

Хууль тогтоомж бий болохоос өмнө уламжлал, зан заншил, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ хүн хоорондын харилцааг зохицуулж байсан<sup>2</sup>.

Ёс суртахуун/moral/, ёс зүйн /ethic/ ялгаатай байдлыг тодорхойлсноор төрийн албан хаагчийн ёс зүйн талаар нэгдмэл ойлголттой болохыг зорин энэ өгүүллийг бичлээ.

Ёс зүй, ёс суртахууны сэдэв нь зөвхөн нэг салбараар хязгаарлагдахгүй, шинжлэх ухааны олон салбар судалдаг хэдий ч төрийн албан хаагчийн ёс зүйн талаар нэгдсэн ойлголттой болсноор тэдэнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Академич Ц.Дамдинсүрэн асан “этика гэдгийг 1) Ёс суртахууны сургаал буюу ёс зүй гэх мэдлэгийн салбар ухаан, 2) Ёс суртахуун гэж мораль гэх үгийг ёс суртахуун, зан суртахуун, 2) Сургаал сургамж гэж Орос- Монгол толь бичигтээ оруулсан бол ёс зүй бол нийгмийн тодорхой тогтолцоонд хүмүүс өөрсдийн авир үйлдэл, харилцан хамаарлыг тохируулахын тулд аяндаа сайн дураараа баримталдаг янз бүрийн хэм хэмжээний цогцсыг буюу ёс суртахууныг судлах зүйлээ болгодог философийн бүрэлдэхүүн мөн<sup>3</sup> гэж тус тус тодорхойлсон.

Судлаач ёс суртахуун, ёс зүйг дараах байдлаар ялган өөрийн саналаа дэвшүүлж байна.

Нэг. ёс суртахууны ойлголт хүмүүсийн харилцаан дах сайн ба муу, зөв ба буруугийн тухай, шударга ёс, үнэнч байх зэрэг хүний зан авирт хамаарах зан суртахууны шаардлага юм. Тиймээс ёс суртахууныг хуульчлах буюу албадлагын шинжтэй болгох гэхээсээ байгууллагын, гэр бүлийн, хамт олны түвшинд удирдамж, хөтөлбөр, заншил, уламжлалд тусгах замаар хүмүүсийг ёс суртахуунлаг болгодог аж.

Хоёр. Ёс зүй бол ёс суртахуун, түүний зарчим, дотоод логикийг судалдаг шинжлэх ухаан буюу гүн ухааны салбар юм. Нөгөө талаас ёс зүй бол хүмүүсийн нийгмийн харилцаанд оролцох, ажил эрхлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд баримталбал зохих үүрэг, хориглох зүйлийг багтаасан хэм хэмжээний шаардлага юм.

Түүнчлэн ёс суртахуун /moral/ хүний бусдад муу зүйл хийхгүй байх итгэл үнэмшилтэй холбоотой бол төрийн албан хаагчийн ёс зүй / ethic civil of servant / бол төрийн албан хаагч төрийн буюу нийтийн алба хашихдаа бусдын төлөө зөв байх ёстойг үүрэгжүүлсэн хэм хэмжээ юм.

Хэрэв ёс суртахуун хүмүүсийн ертөнцийг танин мэдэх үнэт зүйлийн талаарх ерөнхий чиг баримжааг тодорхойлдог бол ёс зүй нь мэргэжлийн үйл ажиллагааны үнэт зүйлийн агуулгыг хэм хэмжээ, шаардлага, хууль, дүрмийн заалтын хэлбэрээр илэрхийлдэг.

Жишээ нь: Дорж бусдад тусламж үзүүлсэн сайхан сэтгэлтэй хүн гэж тодорхойлж байгаа нь ёс суртахууны үнэлэмж бол Дулмаа гэмт хэрэг үйлдсэн хүнийг мэдээлэх хуульд заасан үүргээ биелүүлсэн гэдэг нь түүнийг ёс зүйтэй буюу хуулиа сахин

<sup>2</sup>Н.В.Митрук. *Общая теория юридической ответственности*. 2009.с.14

<sup>3</sup>Ц.Гомбосүрэн. *Философи*. 2008. х.9

биелүүлдэг байдлыг илтгэнэ. Практик хэрэглээнд болон эрдэмтэн судлаачдын бүтээлд ёс зүй, ёс суртахуун хоёрыг хоршуулж хэрэглэх нь түгээмэл байна.

Ёс суртахуун, ёс зүйг ийнхүү ялган тодорхойлох нь төрийн албан хаагчийн ёс зүй, тэдний гаргасан ёс зүйн зөрчил, ёс зүйн хариуцлагын талаар ойлголтуудыг нэгдмэл байдлаар тодорхойлоход ач холбогдолтой гэж үзлээ.

## 2. Арга зүй

Судалгаанд хууль зүйн догматик шинжилгээ, харьцуулсан эрх зүй, түүхэн арга, мөн мэдээллийн эх сурвалжийн шинжилгээг хослон ашигласан. Үндсэн хууль, холбогдох хуулиуд, ҮХЦ-ийн шийдвэрүүд зэрэг анхдагч эх сурвалж болон академик эх сурвалжийг судалж, харьцуулан дүгнэсэн.

## 3. Судалгааны үр дүн

### Нэг. Төрийн албан хаагчийн ёс суртахуун ба ёс зүйн тухай ойлголт, ялгаа

Төрийн албан хаагчийн ёс суртахуун/ *moral*/ гэх ухагдахуунд тухайн албан хаагчийн хувь хүний буюу бодгалийнх нь эрхэмлэдэг үнэт зүйл, дотоод итгэл үнэмшил, зан суртахуун<sup>4</sup> багтана. Төрийн албан хаагч нийгмийн үнэт зүйлд хандаж буй хандлага, бусадтай харьцах зан суртахууных нь шинжээр түүний ёс суртахууны байдлыг тодорхойлж болно. Жишээлбэл, эх орныхоо төлөө амь биеэ хайрлахгүйгээр үнэнч зүтгэх, ард түмэндээ үйлчлэх, багаар ажиллах, манлайлах гэх мэт.

Тиймээс ёс суртахуун нь хүмүүс хоорондын харилцаанд ялгаатай байж болдог учраас төрийн албан хаагчийн зан суртахууныг хуульд хэм хэмжээ болгон /*norm*/ заавал хуульчлан зохицуулах шаардлагагүй гэж зарим судлаачид үздэг. Тодруулбал, ёс суртахууныг төрөөс тогтоодоггүй, тогтоох ч боломжгүй бөгөөд одоо ч бид ёс зүй ба эрх зүйг энэ зарчмыг үндэслэн ёс суртахуун бол сайн дураар үйлдэхүй, эрх зүй бол албадлага гэж ялгадаг<sup>5</sup> гэдэгтэй санал нийлж байна.

Харин төрийн албан хаагчийн ёс суртахууны асуудлыг хууль, захиргааны хэм хэмжээний актад төрийн албан хаагчийн баримталбал зохих зарчим болгон зохицуулах хандлага хувьд улс орнуудын практикт түгээмэл байдаг. Жишээлбэл, Монгол улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд хүнлэг, энэрэнгүй байх, үнэнч, шударга байх, хариуцлагатай байх, манлайлах, хамтач байх гэсэн зарчмыг тодорхойлсон. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 сарын 12-ны өдрийн 51/59 тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын зан суртахууны Олон улсын дүрэм”-ийг нэрлэх хэрэгтэй. Энэхүү дүрмээр төрийн албан хаагчдын үйл ажиллагааны зарчмыг ерөнхий байдлаар тодорхойлсон юм. Европын хууль тогтоомжийн тухайд Европын зөвлөлийн сайд нарын хорооны зөвлөмжийн 2000 оны тавдугаар сарын 11-ний өдрийн хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчдын зан байдлын Загвар дүрэм ихээхэн ач холбогдолтой. Энэхүү Загвар дүрэм нь сонгогдсон төлөөлөгчдөөс бусад төрийн албан хаагч, албан тушаалтнуудад, өөрөөр хэлбэл парламентын гишүүдээс бусад албан хаагчдад хамаардаг.

<sup>4</sup> Нийгмийн шаардлагад тохирох хүний зан авир, хүмүүжил. Монгол хэлний их тайлбар толь.

<sup>5</sup> Ц. Баатартогтох Ёс зүй ба ёс суртахуун хэмээх ойлголтуудын хэрэглээний асуудал. Төрийн захиргааны албаны ёс зүйн хариуцлагын зарим асуудал. илтгэл. Удирдлагын академи.

Уг дүрмийн зорилго нь ёс зүй, шударга байдлын хэм хэмжээг нарийвчлан тайлбарлах замаар түүгээр тогтоосон хэм хэмжээг биелүүлэхэд нь төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн төрийн албан хаагчдаас ямар зүй зохистой зан байдал гарах учиртайг иргэдэд мэдээлэхэд оршино. Тухайлбал, эелдэг байдал, хариуцлага, төвч шударга байдлын зан суртахууны дүрмийг тогтоожээ<sup>6</sup>. ОХУ-д төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмуудыг бүрдүүлэх эрх зүйн эх сурвалж нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2002 оны 885 тоот “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг батлах тухай” зарлигт: “төр, нийгэмд үйлчлэх, хууль ёсны, хүнлэг байх, хариуцлагын, шударга ёсны, үнэнч байх, улс төрийн төвийг сахих” зарчмуудыг тусгажээ<sup>7</sup>.

Иймд аливаа ёс суртахууны зарчмуудыг төрийн албан хаагчид хамтдаа дагаж мөрдөх нь албан үүргээ ухамсартай гүйцэтгэх, төрийн эрх мэдлийг бэхжүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө ажлын үр дүнд хувь нэмэр оруулах үндэс болно гэж үздэг юм байна<sup>8</sup>.

Төрийн албан хаагч өөрийн ёс суртахууны байдалдаа харш үйлдэл гаргавал тухайн албан хаагч сайн дураараа буюу ямар нэгэн албадлагагүйгээр хариуцлагаа хүлээдэг. Тухайлбал, бусдаас өөрийн санаачилгаараа уучлал гуйх, албан тушаалаасаа огцрох зэрэг болно. Энэ үйлдлийг ёс зүйн зөрчил гэж томъёолохгүй ба харин **төрийн албан хаагчийн ёс суртахууны алдаа** гэж тодорхойлох нь зүйтэй болов уу.

Тэгвэл *төрийн албан хаагчийн ёс зүй* гэдэг нь төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхдээ баримталбал зохих үүрэг, хориглох зүйл, хязгаарлалтыг хууль тогтоомжоор тогтоон зохицуулдаг, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хэлнэ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага буюу хэм хэмжээ нь албан тушаалаа хувийн ашиг сонирхолдоо үл ашиглах, шийдвэр гаргахдаа шударга байх, хуульд захирагдах, иргэдэд үйлчлэх тэгш, шударга байх зэрэг агуулга багтдаг. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх буюу алба хаших харилцаандаа баримталбал зохих үүрэг, хориглох зүйл нь нийтлэг ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

Судлаач төрийн албан хаагчийн ёс зүйг дараах байдлаар ангилан тодорхойлов.

- 1) Авлигаас ангид байх
- 2) Ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх
- 3) Өөрийн орлого, зарлагыг мэдүүлж байх
- 4) Илт хууль зөрчсөн шийдвэр гаргахгүй байх
- 5) Төрийн албаны зарчим, үнэт зүйлст харш үйлдэх гаргахгүй байх
- 6) Байгууллагын дотоод дүрэм, журмыг сахих, соёлд хүндэтгэлтэй хандах
- 7) Олон нийтийн өмнө төрийн албан хаагчийн хувиар биеэ зохистой, үлгэр жишээч авч явах, эерэг харилцаа, хандлагатай байх
- 8) Хүрээлэн буй орчинд ээлтэй, нийтийн сайн үйлст манлайлагч байх зэрэг болно<sup>9</sup>.

<sup>6</sup> А.Алтанзул, Ч.Энхбаатар нар. *Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ*. УА, 2024. хуудас 15.

<sup>7</sup> Мөн тэнд.

<sup>8</sup> А.Алтанзул, Ч.Энхбаатар нар. *Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ*. УА, 2024. хуудас 15.

Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээнд төрийн албан хаагчийн ёс суртахууныг илэрхийлдэг зарим зан суртахууныг хууль тогтоомжид тухайлан ёс зүй хэм хэмжээ буюу үүрэг, хориглох зүйлээр зохицуулсан улс орнууд байдаг. Тухайлбал, Монгол улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан үүрэг, хориглох зүйлийн заалтууд нь төрийн албан хаагчийн ёс суртахууны харилцааг зохицуулсан. Жишээлбэл, тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т: “бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх” гэх мэт зан суртахууныг /ёс суртахууны илэрхийлэл/ заавал биелүүлэх үүрэг болгон хуульчлав. Энэ хуульд заасан үүргийг зөрчсөн этгээдэд бусдаас уучлал гуйхыг шаардах замаар хариуцлага гарцаагүй хүлээлгэдэг.

Мөн төрийн албан хаагч “хүрээлэн буй орчинд ээлтэй, нийтийн сайн үйлст манлайлагч байх” ёс суртахуунтай холбоотой зан үйлийг ёс зүйн хэм хэмжээний ангилалтад орууллаа. Одоогийн байдлаар хуульд тухайлан үүрэг болгон зохицуулаагүй ч цаашид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд үүрэг болгон оруулах шаардлагатай гэж судлаач үздэг.

### **Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулж буй хууль тогтоомжийн талаар**

Төрийн албан хаагчийн ёс зүйн дээрх нийтлэг хэм хэмжээг зохицуулж буй 12 хууль, Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан албан тушаалын ангилал тус бүрийн албан хаагчдын ёс зүйг зохицуулж буй 32 хууль, 10 гаруй дүрэм үйлчилдэг.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хуулиас гадна эрх бүхий байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний акт буюу дүрэм, журамд тусгадаг. Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрмийг баталсан. Гэхдээ анхаарах зүйл нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулж буй хуулиудын заалттай дүрмийн заалтыг давхцуулахгүй байх ёстой. Хэрэв энэ шаардлагыг хангаагүй дүрэм, журам гаргах аваас хууль хэрэглээний нэгдмэл байдал бий болохгүй юм. Жишээлбэл, 2019 онд “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газар 33 дугаар тогтоолоороо(одоо хүчингүй болсон) баталсан дүрэм нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хуулиудтай олон тооны давхардал, зөрчилтэй байсан. Хэдийгээр хууль зүйн техникийн дагуу Төрийн албаны тухай хууль нь Засгийн газрын дүрмээсээ дээгүүр эрэмбэлэгддэг ч практикт шийдвэр гаргаж буй албан тушаалтнууд ихэнхдээ хуулийг зөв хэрэглэх мэдлэг, чадвар дутмаг<sup>10</sup> байдгаас төрийн албан хаагчдын гаргасан зөрчилд оновчтой, гэм бурууд нь тохирсон хариуцлага хүлээлгэж чаддаггүй байв.

Түүнчлэн төрийн албан хаагчийн ажиллаж буй салбарын онцлогийг тусгасан уяан хатан зохицуулалтыг тусгай дүрэм, журмаар зохицуулах нь ач холбогдолтой.

<sup>9</sup> А.Алтанзул. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг ангилахын учир холбогдол. Хууль дээдлэх сэтгүүл. ХЗҮХ, 2024 өгүүлэл, Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ. Удирдлагын академи. 2024 судалгааны тайланд дурдсан ангилалтыг дахин томъёолж ангилав. Энэ өгүүлээс төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний ангилал тус бүрийн агуулгыг тодорхойлсон.

<sup>10</sup> Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ. Удирдлагын академи. 2024

Жишээлбэл, Цагдаа, эмч, багш нар гэх мэт салбарын онцлогоос хамаарч бие даасан дүрэм, журмыг эрх бүхий байгууллагаас батлах нь оновчтой. Жишээлбэл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д: иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх нийтлэг ёс зүйн үүргийг эрүүл мэндийн салбарын дүрэмд эелдэг зан байдлыг анхааралтай гэж тухайлан тодорхойлдог бол төрийн тусгай албан хаагчдын хувьд төвийг сахих зан үйлээр анхааралтай хандах гэдгийг авч үздэг байна.

### **Гурав. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил**

Төрийн албан хаагч холбогдох хуульд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг зөрчвөл үйлдлийг/ эс үйлдэхүй/ ёс зүйн зөрчил гаргасан гэж үзнэ.

БНСУ-ын Нийтийн албаны ёс зүйн байдлын тухай хууль (1981)- ийн зорилго төрийн албан хаагч нийтийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих, төрийн албан хаагчийн ёс суртахууныг чанд сахих, хөрөнгө орлогоо үнэн зөв мэдүүлэх, төрийн албан хаагчийн болон улс төрд нэр дэвшигчийн хөрөнгийн эх үүсвэр, хуримтлалыг шалгах, албан тушаалаа ашиглан хууль бусаар хөрөнгөжихийг хориглох, авсан бэлэг дурсгалын зүйлээ тайлагнах, албан тушаалтай холбоотой хувьцааг битүүмжлэх, итгэмжлэх, төрийн албанаас тэтгэвэрт гарсан иргэний зарим хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлах зэрэг асуудалтай холбоотой харилцааг зохицуулна гэжээ . Хэрэв дээрх үйлдлүүдийг гаргавал ёс зүйн зөрчилд тооцон хариуцлага хүлээдэг байна.

Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагч хуульд заасан ёс нийтлэг шаардлага болох үүрэг, хориглох зүйлийг зөрчвөл гэмт хэрэг, захиргааны зөрчил, сахилгын, ёс суртахууны зөрчил гаргасанд тооцогддог/ зураг 1-ээс харна уу/.Тухайлбал, авлигаас ангид байх ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэрэг үйлдсэн гэж эрүүгийн хариуцлага хүлээдэг.

Нөгөө талаас төрийн албан хаагч алба хаших харилцаандаа эрх зүйн хэм хэмжээ буюу хуулийг зөрчинө гэдэг нь логик зөрчилтэй байна гэж судлаач үзэж байна. Учир нь хуулийг бүтээдэг, хэрэгжүүлдэг, хэрэглэдэг этгээд хуулиа өөрөө зөрчинө гэдэг ёс зүйгүй явдал юм.


Иймд төрийн албан хаагч хуульд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ сахин биелүүлэхтэй холбоотой үүрэг, хориглох зүйлийг зөрчвөл ёс зүйн зөрчил гэж томъёолж хэвшүүлэх саналтай байна.

Гэхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гэх нэр томъёоллыг зөвхөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд тодорхойлсон. Тодруулбал, “төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг” гэжээ. Энэ нь төрийн албан хаагчийн зөвхөн харилцаа, хандлага буюу ёс суртахууны хүрээгээр ёс зүйн зөрчлийг тодорхойлж байгаа нь учир дутагдалтай байна. Учир нь ёс зүйн зөрчил бол төрийн албан хаагчийн ёс зүй буюу хуулиар үүрэг болгосон, хязгаарлалт тогтоосон бүх хэм хэмжээг зөрчсөн өргөн агуулгатай юм. Тиймээс Төрийн албан хаагчийн ёс зүйн

тухай хуульд заасан нэр томъёоллыг ёс суртахууны зөрчил гэж тодорхойлох илүү оновчтой болов уу.

Иргэн хуульд заасан үүрэг, хориглох зүйлийг зөрчвөл эрх зүйн зөрчилд тооцох харин төрийн албан хаагч хуульд заасан үүрэг, хориглох зүйлийг зөрчвөл ёс зүйн зөрчил гэж үзэх нь төрийн үнэ цэнэ, эрхэм зорилгод нийцнэ.

### Зураг 1. Эрх зүйн болон ёс зүйн зөрчил, түүний төрлүүд



76

Төрийн албан хаагч хуульд заасан ёс зүйн зөрчил гаргасан бол хууль зүйн хариуцлага хүлээлгэнэ. Энэ нь эрүүгийн, сахилгын, захиргааны, ёс зүйн хариуцлага гэж тодорхойлогдоно. Хэрэв төрийн албан хаагч ёс суртахууны буюу зан суртахуунтай холбоотой хуульд заасан хэм хэмжээг зөрчвөл ёс зүйн зөрчилд тооцон, зөрчил гаргасан этгээдэд ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ. Харин төрийн албан хаагч ёс суртахууны буюу зан суртахууны алдаа гаргавал энэ үйлдэлдээ гэмшин сайн дураараа ёс суртахууны хариуцлага хүлээж болно. Үүнийг ёс зүйн зөрчил гэж үзэн хууль зүйн хариуцлагад тооцохгүй.

#### 4. Дүгнэлт

Эцэст дүгнэвэл:

1. Энэ өгүүлэлт төрийн албан хаагчийн ёс суртахуун /moral/ ба ёс зүй /ethic/ хоёрын ялгаатай байдлыг тодруулж, уг ялгаатай байдлыг нэг мөр ойлгож хэвших шаардлагатай байна.

2. Төрийн албан хаагчийн ёс суртахууны асуудлыг заавал эрх зүйн зохицуулалтад оруулах шаардлагагүй ч, өнөө цаг үед төрийн албан хаагчийн зан суртахууны

доголдолтой холбоотой гомдол маргааны тоо их байгаа тохиолдолд зарим зан суртахууныг хуульчлах зөв гэж үзлээ.

3. Төрийн албан хаагчийн ёс зүй бол мэргэжлийн ёс зүйн нэг үндсэн төрөл бөгөөд нэр томъёоны хувьд ёс зүйн гэж хэлэх нь оновчтой юм.

4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ буюу хуульд заасан үүрэг, хориглох зүйлийг зөрчсөн бүх үйлдлийг ёс зүйн зөрчил гэж нэгдмэл байдлаар томъёолох шаардлагатай байна. Ёс зүйн зөрчлийн хэлбэрүүдэд гэмт хэрэг, захиргааны, сахилгын, ёс суртахууны зөрчил багтана.

### **5. Эх сурвалж:**

- Ц. Баатартогтох. *Ёс зүй ба ёс суртахуун хэмээх ойлголтуудын хэрэглээний асуудалд. Төрийн захиргааны албаны ёс зүйн хариуцлагын зарим асуудал. 2019.*
- Я.Долгоржав, Монгол улсын төрийн албаны үнэт зүйлс (эрхэмжэ), уламжлал. Улаанбаатар: Удирдлагын академи. 2021.
- Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ. Удирдлагын академи. 2024. Судалгааны тайлан.

---oOo---